BULIGAR

“БУЛИГААР” ХК-ИЙН САНХҮҮГИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Жилийн үйл ажиллагааны тайлагнал */маягт 2/*	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа	2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	“Булигаар” ХК РД:2039184 MSE: MBG Утас: 99626299 И-мэйл: info@buligaar.com Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг 17042, Чингисийн өргөн чөлөө, АШҮ-н хашаа
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Гутлын дээд биеийн материал үйлдвэрлэх Арьс шир боловсруулалт Худалдаа Худалдааны зуучлал Гадаад худалдаа
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	400,212,000
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Ерөнхий нягтлан бодогч Н.Тэмүүжин ТУЗ-ийн нарийн бичиг Н.Сарантуяа Хянасан: Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг
1.	***Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан*** */хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/*

	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Эргэлтийн хөрөнгийн дүн:	19,181,248,544.28
		Эргэлтийн бус хөрөнгийн дүн:	18,529,487,034.71
		Нийт хөрөнгийн дүн:	37,710,735,578.99
		Өр төлбөрийн нийт дүн:	26,225,460,856.33
		Эздийн өмчийн дүн:	11,485,274,722.66
		Өр төлбөр ба эздийн өмчийн дүн:	37,710,735,578.99
	Орлогын тайлан	Борлуулалтын орлого:	8,508,053,836.30
		Борлуулсан бүтээгдэхүүний өртөг:	7,138,886,946.25
		Нийт ашиг:	1,369,166,890.05
		Түрээсийн орлого	90,838,325.38
		Хүүний орлого	7,238,331.92
		Бусад орлого:	
		Борлуулалт маркетингийн зардал	9,123,342.26
		Ерөнхий удирдлагын зардал	777,067,061.93
		Бусад зардал:	2,627,272.73
		Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	-4,109,004.65
		Татвар төлөхийн өмнөх ашиг:	674,316,865.78
		Орлогын татварын зардал:	68,106,378.54
		Тайлант үеийн цэвэр ашиг:	606,210,487.24
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	2025 оны 12 сарын 31-ны үлдэгдэл:	12,870,712,691.93
		2026 оны 09 сарын 30-ны үлдэгдэл:	13,476,923,179.17
		2026 оны тайлант үеийн цэвэр ашиг:	606,210,487.24
	Мөнгөн гүйлгээний тайлан	Мөнгөн орлогын дүн:	9,539,348,897.83
		Мөнгөн зарлагын дүн:	7,716,494,042.56
		Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн:	1,822,854,855.27
		Мөнгөн орлогын дүн	0.00
		Мөнгөн зарлагын дүн	173,328,857.00
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-173,328,857.00
		Мөнгөн орлогын дүн	2,163,754,000.00
		Мөнгөн зарлагын дүн:	1,658,817,972.50
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	504,936,027.50
		Валютын ханшийн зөрүү	-2,030,759.05
		Цэвэр мөнгөн гүйлгээ:	2,152,431,266.72
		Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	40,124,674.34
		Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл :	2,192,555,941.06

2.	***Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт***	
	Компанийн 2026 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн дараагийн ээлжит хурлаар хэлэлцэж, Аудитын хорооны дүгнэлтийг гаргах бөгөөд улирлын тайланг холбогдох журмын дагуу хуулийн хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, МХБ-д хүргүүлж байна.	
3.	***Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт***	
3.1.	*Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/*	Санхүүгийн үзүүлэлтүүд **Ашигт ажиллагаа**
3.2.	*Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт*	Нийт хөрөнгийн өгөөж (ROA) 1.66% Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 5.42% **Өөрчлөлтийн хувь /оны эхнээс/** Нийт активын өөрчлөлт 6.72% Зээлийн багцын өөрчлөлт 16.37% **Хөрөнгөд эзлэх хувь** Өөрийн хөрөнгө /Нийт хөрөнгө/ 30.46% Өр төлбөр /Нийт хөрөнгө/ 69.54% **Хөрвөх чадварын харьцаа** Хөрвөх чадварын хөрөнгө/ 2.04% Татан төвлөрүүлсэн хөрөнгө 0.11%
3.3.	*Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл*	• 2026 оны 3-р улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад борлуулалт 31.92%-иар өссөн, цэвэр ашиг 505.60%-иар өссөн байна. • Арьс ширний үйлдвэрүүдийг шинэ суурьшлын бүс болох эмээлт рүү нүүлгэх төрийн бодлогын чиглэл хандлага тодорхой болсон. • Ижил төрлийн бүтээгдэхүүний хяналтгүй импортын эсрэг үйлдвэрлэлийн технологийг тогтвортой байлгах, шинэчлэлт хийх бодлого барьж ажиллаж байгаа. • Мэргэжлийн болон менежментийн ур чадвар бүхий ажиллах хүчний тасалдал бий болсон төдийгүй энэ байдал цаашид үргэлжлэх хандлагатай байна. Энэхүү асуудал нь салбар төдийгүй улсын хэмжээнд яригдах болсон бөгөөд компани ажиллах хүчний хомсдлыг нөхөх зорилгоор гадаадын гэрээт ажилчдыг ажиллуулж байна. • Түүхий эд, эрчим хүч, тээвэр болон бусад

		үйлдвэрлэлийн зардлын өсөлттэй холбоотойгоор компанийн бүтээгдэхүүний борлуулалтын үнийг 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн мөрдүүлэхээр шийдвэрлэж, харилцагч, хэрэглэгчдэд 9 дүгээр сард урьдчилан мэдэгдсэн. • Гадаад зах зээлийг тэлэх бодлогын хүрээнд ITDM төсөл, арьс ширний кластерийн гишүүдтэй хамтран ILM Offenbach (ХБНГУ), MIPEL (БНИУ) олон улсын үзэсгэлэнд чацарганы хандаар идээлсэн сарлагийн арьсан бүтээгдэхүүнээр оролцож, Монгол арьсыг олон улсад сурталчиллаа. • Технологи, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах зорилгоор БНХАУ-ын Dowell компанитай хамтран лабораторийн туршилт хийж, гутлын дотрын зориулалттай үхрийн арьсны физик, механик үзүүлэлт олон улсын стандартад нийцэж буйг шинжилгээгээр баталгаажуулав. • Чанар, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдлын ISO 9001, ISO 14001, ISO 45001 стандартын шаардлагыг нэгтгэсэн Нэгдсэн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хийж байна.
3.4.	*Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл*	Санхүүгийн тайлангаас гадуурх бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй болно.
4.	***Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/***	
	Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно.	
5.	***Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл***	
	Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй болно.	
6.	***Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл***	

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллав. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн:

1. Төмөрбаатар овогтой Болд
2. Чулуунбаатар овогтой Нямдорж
3. Жадамба овогтой Эрдэнэбат

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн:

1. Батчулуун овогтой Анхболд
2. Анхболд овогтой Энхмэнд
3. Батчулуун овогтой Баянжаргал
4. Бямбабаяр овогтой Баттүшиг
5. Довжид овогтой Гансүх
6. Цэрэндагва овогтой Мөнхлхагва

"Булигаар" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн хүрээнд Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар ханган, компанийн стратегийн зорилтот түвшин, санхүү эдийн засгийн үзүүлэлт, бизнес төлөвлөгөөг батлан, холбогдох чиг үүрэг, зөвлөмжүүдийг өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.

Дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороог ажиллуулж, засаглалын болон дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан.

Хувьцаа эзэмшигчдийн 2026.04.17-ны өдрийн ээлжит хурлаар ТУЗ-ийн 9 гишүүнийг 1 жилийн хугацаатайгаар сонгосон.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаан, ирц: ТУЗ-ийн дэргэд 3 хороо үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ТУЗ-ийн ээлжит хурал улирал тутам, хороод жилд 2 удаа ээлжит хурлаа зохион байгуулан компанийн тайлан мэдээлэлтэй танилцаж, ТУЗ-ийн зүгээс компанийн удирдлагуудад санал, зөвлөмж, үүрэг даалгавар өгч ажилладаг.

Тайлант 3 дугаар улирлын хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдаагүй бөгөөд ТУЗ-ийн гишүүд компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цахим хэлбэрээр тогтмол хүлээн авч ажилласан.

ТУЗ-ӨӨС ШИЙДВЭРЛЭСЭН ТОГТООЛЫН АГУУЛГА

Тайлант хугацаанд ТУЗ-ийн тогтоол гараагүй болно.

ТУЗ БОЛОН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ХУРАЛДААН

Тайлант хугацаанд ТУЗ-ийн хурал хуралдаагүй болно.

ХУРЛЫН ИРЦ

ТУЗ-ийн гишүүд нь ТУЗ-ийн хурлын мэдээллийг цаг тухай бүрд нь и-мэйлээр хүлээн

	авч, биечлэн оролцох боломжгүй тохиолдолд саналаа цахим шуудангаар урьдчилан илгээдэг. Тайлант хугацаанд ТУЗ-ийн хурал хуралдаагүй тул хурлын ирцийг тооцоогүй болно. Компани нь сайн засаглалын туршлагуудаас суралцах, хэрэгжүүлэх, мэдээллийн нээлттэй ил тод байдлын зарчмыг баримтлан хувьцаа эзэмшигчдээ шаардлагатай мэдээллээр ханган, санал хүсэлт, асуултад тухай бүр хариу өгч байгаа.
	ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлж, гүйцэтгэх удирдлагын багийг удирдан ажилладаг. Тайлант хугацаанд компанийн гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүн: • Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг *Булигаар ХК-д ажиллаж буй хугацаа:* 7 жил *Булигаар ХК-ийн хувьцааны эзэмшил:* 0.002% • Ерөнхий нягтлан бодогч Н.Тэмүүжин *Булигаар ХК-д ажиллаж буй хугацаа:* 7 жил *Булигаар ХК-ийн хувьцааны эзэмшил:* Хувьцаа эзэмшдэггүй.
7.	***Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл***

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСЫН ХЭРЭГЖИЛТ

Компани нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022.03.23-ны өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ыг үйл ажиллагаандаа даган мөрдөн ажиллаж байна. Тус үнэлгээ нь 2024 оны жилийн эцсийн байдлаар 91.7%-тай үнэлэгдэж байсан бол 2025 оны эхний хагас жилийн үнэлгээгээр 93.1%-ийн гүйцэтгэлтэй гарсан нь өмнөх оны үнэлгээнээс 1.5%-иар өсч 5-р байранд жагсав. "Компанийн засаглалын кодекс" нь тасралтгүй хэрэгжиж, үйл ажиллагааны онцлогоос хамаарч үнэлгээ нь тухай бүр шинэчлэгддэг тул компанийн зүгээс 100%-ийн гүйцэтгэлээ хангахын тулд хүчин зүтгэлээ гарган ажиллах болно.

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	2024.12.31		2025.06.30	
			СЗХ-ны хяналтын оноо	Үнэлгээний хувь	СЗХ-ны хяналтын оноо	Үнэлгээний хувь
1.	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	100%	11	91.7%
2.	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%	10	100%
3.	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	4	66.7%	4	66.7%
4.	Аудит, хяналтын тогтолцоо	6	5	83.3%	6	100%
5.	Эрсдэлийн удирдлага	8	8	100%	8	100%
6.	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%	6	100%
7.	Оролцогч талуудын эрх ашиг	8	6	75%	7	87.5%
8.	Компанийн соёл	6	6	100%	6	100%
9.	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	90%	9	90%

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025.09.25-ны өдрийн А/358 тоот тушаалаар хувьцаат компаниудын 2024,2025 оны үзүүлэлтийг харгалзан үнэт цаасны ангиллыг шинэчлэн тогтооход "Булигаар" ХК нь III ангилалаас II ангилал руу дэвшсэн байна.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

2026 оны 3 дугаар улирлын хугацаанд дараах тайлан мэдээллийг хуулийн хугацаанд СЗХ болон МХБ руу тус тус илгээн, олон нийтэд тайлагнан ажилласан.

- 2026 оны хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан
- 2026 оны хагас жилийн Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн тайлан

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тайлант хугацаанд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт гараагүй болно. Булигаар ХК нь 2026.09.30-ны өдрийн байдлаар 400,212,000 хувьцааг 931 хувьцаа эзэмшигчидтэй байна.

	Нийт хувьцаа эзэмшигчдээс 5 ба түүнээс дээш хувийг 3 хувьцаа эзэмшигч буюу 88.11%-ийг дараах нэр бүхий хувьцаа эзэмшигчид нь эзэмшдэг болно. Үүнд: ***Нэр*** — ***Тоо ширхэг*** — ***Хувь*** А.Энхмэнд — 156,630,000 — 39.14% Б.Анхболд — 145,996,000 — 36.48% Б.Баянжаргал — 50,000,000 — 12.49% Бусад 928 хувьцаа эзэмшигч — 47,586,000 — 11.89% Нийт дүн — 400,212,000 НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ Булигаар ХК-ийн ТУЗ-ийн 2026.02.13-ны өдрийн №02/26 тоот тогтоолын дагуу компанийн 2025 оны санхүүгийн жилийн ашигт ажиллагаа зорилтод түвшинд хүрээгүй, Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадварт нөлөөлж болзошгүй тул Булигаар ХК-ийн ногдол ашгийн бодлогын 2.2. дахь хэсгийн 2.2.1. дэх заалтыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ “Булигаар” ХК нь оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах үйл ажиллагааг идэвхжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд компанийн үйл ажиллагаатай биечлэн танилцах хүсэлтэй оролцогч талуудын хүсэлтийг хүлээн авч үйлдвэрийн онцлог, компанийн үйл ажиллагааг нээлттэй танилцуулдаг байгаа. Тайлант хугацаанд Хан-Уул дүүргийн Засаг дарга Б.Цэрэн, дүүргийн “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв”-ийн дарга Т.Рэгзэдмаа нар (7 дугаар сар), Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар болон сумдын хөдөө аж ахуй, хоршоо, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтнүүд (9 дүгээр сар), түүхэн кино бүтээлдээ арьсан хувцас, хэрэгсэл урлахаар хамтран ажиллаж буй “Фантастик Продакшн”-ы уран бүтээлчид (9 дүгээр сар) үйлдвэрийн үйл ажиллагаа, арьс боловсруулах технологийн үе шаттай биечлэн танилцлаа.
8	***Үйл ажиллагаатай холбоотой бусад нэмэлт мэдээлэл***
	ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА “БУЛИГААР” ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА Хан-Уул дүүргийн Засаг дарга Б.Цэрэн, дүүргийн “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв”-ийн дарга Т.Рэгзэдмаа нар Булигаар ХК-ийн үйлдвэрлэл, үйл ажиллагаатай танилцаж, цаашид хамтран ажиллах талаар санал солилцлоо.





“БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХИМИЙН СУДАЛГАА БА АШИГЛАЛТ” ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫГ ИВЭЭН ТЭТГЭВ


Химийн хүрээлэнгээс зохион байгуулсан “Байгалийн нөөцийн химийн судалгаа ба ашиглалт” олон улсын эрдэм шинжилгээний 6 дугаар хуралд Булигаар ХК ивээн тэтгэгч байгууллагаар оролцож, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг дэмжлээ.

DOWELL КОМПАНИТАЙ ХАМТРАН ТЕХНОЛОГИ ХӨГЖҮҮЛЭХ ТУРШИЛТ ХИЙЛЭЭ

Булигаар ХК-ийн технологийн баг бүрэлдэхүүн БНХАУ-ын Шанхай хотод арьс шир боловсруулах технологи, химийн материал үйлдвэрлэгч Dowell компанийн лабораторид ажиллаж, технологи хөгжүүлэх хамтарсан туршилт хийж, туршлага солилцлоо.

Мөн компанийн 2024 оноос үйлдвэрлэж буй гутлын дотрын зориулалттай үхрийн арьсыг Dowell компанийн лабораторид ус чийг татах чадвар, тасралт даалт зэрэг физик, механик үзүүлэлтээр бүрэн шинжлүүлсэн бөгөөд шинжилгээний үр дүнгээр олон улсын стандартад нийцэж байгаа нь батлагдлаа.




检测报告Test Report

НҮБ-ЫН ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ КОНВЕНЦИЙН COP17 ЧУУЛГАНЫ ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦОВ

2026 оны 8 дугаар сарын 17–28-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо болсон НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн Талуудын 17 дахь бага хурал (UNCCD COP17)-ын Ногоон бүсэд ХХААХҮЯ-ны хөнгөн, хүнсний үйлдвэрийн хэсэгт Булигаар ХК үзэсгэлэнгээ дэлгэн оролцлоо.

Үзэсгэлэнгээр арьс ширний үйлдвэрлэлийн хатуу хаягдлыг дахин боловсруулж органик шингэн амин хүчлийн бордоо үйлдвэрлэх тойрог эдийн засгийн шийдлийг танилцуулсан нь хог хаягдлыг хөрс сэргээх бүтээгдэхүүн болгох замаар цөлжилттэй тэмцэх чуулганы зорилготой нийцсэн юм.



ILM OFFENBACH, MIPEL MILANO ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭНД МОНГОЛ АРЬСЫГ СУРТАЛЧИЛЛАА

МҮХАҮТ-ын дэргэдэх Европын Холбооны санхүүжилттэй ITDM төсөл, МАШҮХ-ны арьс ширний кластерийн гишүүд 2026 оны 8 дугаар сарын 29–31-нд ХБНГУ-ын Оффенбах хотод болсон ILM Offenbach 2026, 9 дүгээр сарын 13–15-нд БНИУ-ын Милан хотод болсон MIPEL 2026 олон улсын үзэсгэлэнд “Mongolian Green Labels” брэндээр амжилттай оролцлоо.

Үзэсгэлэнд толилуулсан цүнх, хэтэвч, жижиг эдлэлүүдийг Булигаар ХК-д 100% чацарганы хандаар идээлж боловсруулсан сарлагийн арьсаар кластерийн гишүүн компаниуд урласан бөгөөд чацарганы хандаар идээлэх туршилт, судалгаа, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн бүх үе шатыг төслийн оролцогч талуудтай хамтран гүйцэтгэсэн.





“НАМРЫН НОГООН ӨДРҮҮД – 2026” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНД ОРОЛЦОВ

ХХААХҮЯ, “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК-аас 2026 оны 9 дүгээр сарын 21–27-ны өдрүүдэд Төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулсан “Намрын ногоон өдрүүд – 2026” үзэсгэлэн худалдаанд Булигаар ХК үндэсний үйлдвэрлэгчийн хувиар оролцож, Монгол үхрийн арьсаар боловсруулсан олон өнгө, төрлийн гутал, цүнхний арьсаа хэрэглэгчдэд танилцууллаа. Мөн жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Намрын хямдралтай худалдаа”-г үйлдвэрийн төв дэлгүүрт зохион байгуулахаар товлосон.



	УСНЫ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ Уурын конденсаци үүссэн хаягдал усыг тусгай зориулалтын танканд хүлээн авч тоног төхөөрөмж угаах, цехийн цэвэрлэгээ үйлчилгээ, арьс боловсруулах анхан шатны тордолгоонд хэрэглэж байна. ТАЙЛАНТ ХУГАЦААНЫ ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ “Булигаар” ХК чанар, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдлыг нэгтгэсэн Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлогоо 2026 оны 10 дугаар сард баталж, ISO 9001, ISO 14001, ISO 45001 стандартын баталгаажуулалтын эхний шатны аудитыг 2026.10.15–16-ны өдрүүдэд амжилттай давлаа.
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Б.Баттүшиг Албан тушаал: “Булигаар” ХК-ийн Гүйцэтгэх захирал Гарын үсэг: ..... *(Тамга/тэмдэг)*	
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Н.Тэмүүжин Албан тушаал: Ерөнхий нягтлан бодогч Гарын үсэг: ..... Овог, нэр: Н.Сарантуяа Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичиг Гарын үсэг:	